

Батлав:

БОАЖЯ, ХБОБНУГ-ын дарга:

/ А. ЭНХБАТ /



Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:
“НОЁН ТОХОЙ ТРЕЙД” ХХК-ийн:ЗАХИРАЛ

 /Ц.НООСТОЙ /

**ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН НУТАГТ ОРШИХ
“БОР ТАЛ”-ЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫГИЛ АРГААР
АШИГЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/Тусгай зөвшөөрлийн дугаар MV-007039/

/Аж ахуй нэгжийн регистрийн дугаар 5282586 /

Хянасан:

БОАЖЯ, ХБОБНУГ-ын

ахлах мэргэжилтэн:

/ Ц. ЖАРГАЛНЭМЭХ /

Төв аймгийн БОАЖГ-ын

ахлах мэргэжилтэн:

/ С.ЭРДЭНЭЦОГТ /

Боловсруулсан:

“НОЁН ТОХОЙ ТРЕЙД” ХХК-ийн

Байгаль орчны мэргэжилтэн:



/ Г. НАРАНГОО /

ГАРЧИГ

I. ОРШИЛ	2
II. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
II.2. ҮЙЛДВЭРЛЭХ БҮТЭЭГДЭХҮҮН	3
II.3. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ, ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА	3
II.5. БҮТЭЭГДЭХҮҮН ГАРГАЛТЫН ТООЦОО	3
II.6. ХҮНИЙ НӨӨЦ	3
II.7. Төслийн байршил.....	3
II.8. Орд ашиглах тусгай зөвшөөрөл.....	5
II.9. Ордын нөөцийн тооцоо.....	5
II.10. Уурхайн ажлын горим.....	6
II.11. Уурхайн нээлт, ашиглалтын систем.....	6
II.12. Шимт хөрс хуулалт.....	6
II.13. Угаан баяжуулах хэсэг.....	7
II.14. БҮТЭЭГДЭХҮҮН ГАРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	7
II.15. Ажиллах хүчний тооцоо.....	7
II.16. Барилга байгууламж.....	7
II.16.1. Уурхайн тосгон.....	8
II.16.2. Холбооны байгууламж.....	8
II.16.3. Түлшний агуулах.....	8
II.16.4. Засвар механикийн барилга байгууламж.....	8
II.16.5. Цахилгаан хангамж.....	8
II.16.6. Аянгаас хамгаалах байгууламж.....	8
II.17.1. Усан хангамж, усны хэрэглээ.....	9
II.18. Төслийн эдийн засаг.....	11
III. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	12
III.1. Байгаль орчны төлөв байдал.....	12
IV. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	14
IV.1. Газрын гадаргад үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	14
IV.2. Агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	14
IV.3. Усан орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	14
IV.4. Хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	14
IV.5. Ургамлан нөмрөг.....	14
IV.6. Амьтан.....	15
IV.7. Нийгэм, эдийн засагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	15
V.5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	15
VI. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	17
VI.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	17
VI.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	20
VI.2.1. Тэрбум мод төслийн хүрээнд.....	20
ХҮСНЭГТ №13 ТЭРБУМ МОД ТӨСЛИЙН ХҮРЭЭНД	20
VI.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	20
VI.4. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө.....	20
VI.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	20
VI.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	20
VI.9. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө.....	23
VI.10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	24
V.11. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ЗАРЦУУЛАХ НИЙТ ЗАРДАЛ	27
VIII. ДҮГНЭЛТ	28
АШИГЛАСАН МАТЕРИАЛ, НОМ ЗОХИОЛ	29

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт №1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	3
Хүснэгт №2. Талбайн цэгүүдийн солбицол	3
Хүснэгт №3. Ил уурхайн технологийн агуулга, бүрдэл.....	6
Хүснэгт №4. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	23
Хүснэгт №5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө	25

I. ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь алтны шороон ордын үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм, журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Шижиргоулд” ХХК-аас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

“Бор тал” нэртэй алтны шороон орд төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэх юм.

БОМТ боловсруулах аргачлал:

Тус төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчин, ногоон хөгжлийн яамны сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29 –ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт холбогдох байууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

“Бор тал” Алтны шороон ордын БОМТ-нд 2023 онд нийт 14,4 сая төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

II. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хүснэгт №1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

1	Аж ахуйн нэгжийн нэр		“Ноён тохой трейд” ХХК
2	Улсын бүртгэлийн дугаар		9011048087
3	Регистрийн дугаар		2774666
4	Төслийн нэр		“Бор тал” нэртэй алтны шороон орд ашиглах төсөл
5	Төслийн	Аймаг	Төв аймаг
6	байршил	Сум/	Сэргэлэн сум
7	Аж ахуйн	Аймаг/Хот	Улаанбаатар хот
8	нэгжийн	Сум/Дүүрэг	Баянгол дүүрэг
9	хаяг	Баг/Хороо	10-р Хороолол
10		Гудамж/Байр	11-09 тоот.
11	Захирлын	Нэр	Ц. Ноостой
12	мэдээлэл	Утас	88115786

II.1.Төслийн нэр

“Бор тал” нэртэй алтны шороон орд.

II.2. Үйлдвэрлэх бүтээгдэхүүн

Алт

II.3. Төслийн хүчин чадал, үргэлжлэх хугацаа

Бор талын алтны шороон ордын нөөцийг 2 жилийн хугацаанд, жилийн 105.0 мян.м³ элс олборлон баяжуулах хүчин чадалтайгаар төлөвлөсөн.

II.4. Ашиглалтын технологи

Гадаад болон дотоод овоолготой авто тээвэртэй ашиглалтын системээр ашиглана.

II.5. Бүтээгдэхүүн гаргалтын тооцоо

Бор талын алтны шороон ордын нийт үйлдвэрлэлийн нөөц нь 0.07 гр/м³ агуулга бүхий 169.45 мян.м³ элс, шлихээр 11.46 кг буюу химийн цэврээр 10.11 кг алт байна. Үүнийг гравитацийн аргаар баяжуулж, 92.5 хувийн металл авалттайгаар төслийн нийт хугацаанд 10.6 кг шлихийн алт, химийн цэврээр 9.33 кг алт үйлдвэрлэнэ.

II.6. Хүний нөөц


“Ноён тохой трейд” ХХК-ийн уурхайд эхний жилд 128 хоног, 2 дахь жилд 185 хоног ажиллана.

II.7. Төслийн байршил

Улаанбаатар хотоос урагш 80 км, Төв аймгийн Зуунмод хотоос зүүн тийш 70 км, Сэргэлэн сумын төвөөс зүүн тийш 50 км, Налайх дүүргээс урагш 30 км, Баян сумаас 28 км-т байрладаг.

Хүснэгт №2. Талбайн цэгүүдийн солбицол

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	107	21	38.44	47	29	41.72
2	107	21	38.33	47	30	37.79
3	107	21	12.33	47	30	37.79
4	107	21	12.45	47	29	41.72



II.8. Орд ашиглах тусгай зөвшөөрөл

Ашигт Малтмалын Газраас “Ноён тохой трейд” ХХК-нд Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших “Бор тал”-ын алтны шороон орд нэртэй газар 94.21 га талбай бүхий уурхайн эдэлбэрт ашигт малтмал ашиглах эрхийг олгож MV-007039 дугаар бүхий гэрчилгээг 2004 оны 03 сарын 08-ны өдөр олгосон байна.

II.9. Ордын нөөцийн тооцоо

Бор талын алтны шороон алт агуулсан элсний ул нь газрын гадаргуугаас хамгийн ихдээ 1.8 метр гүнд оршиж байгаа бөгөөд Уурхай эцсийн хүрээ хязгаарыг тодорхойлон ашиглалтын нөөцийг тооцоход нийт нөөцөөс уурхайн хүрээ хязгаарт С зэрэглэлээр 122.72 мян.м³ элс /10.11 кг алт хими цэвэр/ багтаж байна.

Хүснэгт №3. Ашиглалтын нөөц, /Сорьц-880.0/

Блокийн дугаар	Блокийн талбай	Хөрсний зузаан	Элсний зузаан	Хөрс хуулалт	Элсний нөөц	Дундаж агуулга /шлих/	Металлын нөөц /Шлих/	Металлын нөөц /хими цэвэр/
Х.нэгж	/мян.м ² /	/м/	/м/	/мян.м ³ /	/мян.м ³ /	гр/м ³	/кг/	/кг/
Дээд давхарга								
С-1	2.89	0.80	0.40	2.31	1.15	0.100	0.12	0.10
С-2	6.23	0.60	0.30	3.91	2.14	0.095	0.20	0.18
С-3	6.59	0.80	0.30	4.94	1.65	0.136	0.22	0.20
С-4	21.11	1.10	0.40	23.93	8.44	0.130	1.09	0.96
С-5	30.77	1.10	0.40	34.87	13.54	0.103	1.39	1.23
С-6	3.47	1.10	0.20	3.71	0.70	0.091	0.06	0.06
С-7	12.91	1.20	0.50	15.13	6.64	0.093	0.61	0.54
С-8	1.35	0.40	0.60	0.54	0.81	0.240	0.19	0.17
С-9	3.50	0.60	0.20	2.10	0.70	0.113	0.08	0.07
С-10	1.52	0.20	0.20	0.30	0.30	0.155	0.05	0.04
С-11	15.60	1.10	0.30	16.38	5.07	0.062	0.31	0.28
С-12	26.02	0.90	0.60	22.67	16.73	0.074	1.24	1.10
С-13	32.37	0.80	0.60	26.97	20.86	0.066	1.38	1.21
С-14	25.36	0.90	0.60	22.27	15.88	0.129	2.04	1.80
С-15	16.04	1.00	0.70	15.61	11.55	0.062	0.72	0.63
С-16	8.08	0.80	0.60	6.28	4.67	0.204	0.95	0.84
С-17	8.96	0.80	1.00	6.87	8.66	0.066	0.57	0.50
С-18	6.23	0.80	0.40	4.98	2.28	0.060	0.14	0.12
Нийт В	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Нийт С	228.99	0.85	0.60	213.78	121.76	0.093	11.36	10.03
Нийт (В+С)	228.99	0.85	0.60	213.78	121.76	0.093	11.36	10.03
Доод давхарга								
С-19	0.56	0.80	0.40	0.44	0.22	0.150	0.03	0.02
С-20	1.84	0.90	0.40	1.66	0.74	0.098	0.07	0.06
Нийт В	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Нийт С	2.40	0.85	0.60	2.10	0.96	0.104	0.10	0.08
Нийт (В+С)	2.40	0.85	0.60	2.10	0.96	0.104	0.10	0.08
Нийт В	-	-	-	-	-	-	-	-
Нийт С	231.38	0.80	0.40	215.88	122.72	0.093	11.46	10.11

Нийт (В+С)	231.38	0.80	0.40	215.88	122.72	0.093	11.46	10.11
------------	--------	------	------	--------	--------	-------	-------	-------

Хүчин чадал

Ил уурхайн улирал бүрийн олборлолт харилцан адилгүй байх ба эхний жилд 64.64 мян.м³, 2 дахь жилд 104.81 мян.м³ элс олборлохоор төлөвлөсөн.

Ил уурхайн олборлолтыг төлөвлөсөн хүчин чадлаар тооцоход Бор талын алтны шороон ордын нөөцийг 2 жилийн хугацаанд олборлохоор байна.

II.10. Уурхайн ажлын горим

“Ноён тохой трейд” ХХК нь Бор талын алтны шороон ордын хөрс хуулалт, олборлолтын ажлыг жилийн II-р улирлаас III-р улирал хүртэл хугацаанд явуулна. Ил уурхайн олборлолтыг төлөвлөсөн хүчин чадлаар тооцоход 2 жилийн хугацаанд олборлохоор байна.

Хүснэгт №4. Ил уурхайн ажлын горим

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ
1	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12
2	Бүтээлтэй ажиллах хугацаа	цаг	10
3	Хоног дахь ээлжийн тоо	ээлж/хон	1
4	Жилд ажиллах хоногийн тоо	хоног/жил	77
5	Жилд ажиллах ээлжийн тоо	ээлж/жил	77
6	Жилийн ажлын цагийн хэмжээ	цаг/жил	770
7	Цаг ашиглалт	%	83
8	Жилд ажиллах бодит цаг	цаг	639

II.11. Уурхайн нээлт, ашиглалтын систем

Уурхайн С-2 блокоос эхлэн олборлолт явуулах бөгөөд замын ерөнхий схем нь уурхайн баруун хойд хажууг даган өгсөж 1564 м түвшин хүрнэ.

Ашиглалтын технологи: Бор талын алтны шороон ордын хөрсний зузаан нь таазны бохирдол хасаж тооцсоноор дунджаар 0.74 м байна. Иймд шимт хөрсийг 0.2 м зузаантайгаар хуулан овоолно.

Ордын алт агуулсан элс нь хэвтээ ойролцоогоор 8⁰ уналтай, нөөцийн блокуудын өргөн жигд үргэлжилдэг тул ашиглалт явуулсан талбайд дотоод овоолго хийж ашиглах ба ордын ашиглалтанд ил аргаар авто тээвэртэй гадаад дотоод овоолготой ашиглалтын системийг ашиглаж байна.

Хүснэгт №5. Ил уурхайн технологийн агуулга, бүрдэл

Технологи	Үндсэн ажил	Технологийн процессууд
Ил аргаар авто тээвэртэй, гадаад, дотоод овоолготой ашиглалтын технологи	1. Хөрс хуулалт	1.1 Экскаваци
	2. Олборлолт	1.2 Ухаж ачих
		1.3 Тээвэрлэх
		1.4 Овоолох (агуулахад хураах)

II.12. Шимт хөрс хуулалт

Шимт хөрсийг Т-170 маркийн бульдозероор түрж шимт хөрсний овоолгод овоолно. Шимт хөрсний овоолгыг 35⁰ градусын налуутайгаар үерийн ус болон салхины нөлөө бага байх газар байгуулна. Шимт хөрсийг уурхайн талбайгаас 0.2 метр зузаантайгаар 46.28 мян.м³ /сийрэгжээгүйгээр/ шимт хөрс хуулж овоолно.

Хүснэгт №6. Шимт хөрс хуулалт

Ашиглалтын жилүүд	Шимт хөрс хуулалт, мян.м ³		
	Нуур орчмын талбай	Уурхайн талбай	Нийт

1 дэх жил	1.37	18.06	19.43
2 дахь жил		37.47	37.47
Нийт	1.37	55.53	56.90

II.13. Угаан баяжуулах хэсэг

Угаан ангилах төхөөрөмжийн хүрдэн шүүрийн доод ангиллын бүтээгдэхүүн шлюзийн баяжуулалт руу орно. Шлюзны баяжмалыг ээлжиндээ 1 удаа /8 цаг тутамд/ авах ба баяжмал хадгалах саванд цуглуулна. Цуглуулсан баяжмалыг баяжуулах ширээгээр гүйцээн баяжуулна. Баяжуулах ширээнээс шлихийн алт, завсрын бүтээгдэхүүн, хаягдал гэсэн 3 бүтээгдэхүүн гарна.

II.14. Бүтээгдэхүүн гаргалтын төлөвлөгөө

“Бор тал” -ын алтны шороон ордын нийт үйлдвэрлэлийн нөөц нь 51.66 мян.м³ элс, 1.12 гр/м³ агуулгатай элсэн дэх алт нь 58.05 кг буюу химийн цэврээр 50.5 кг алт агуулсан элсний нөөцтэй. Үүнийг гравитацийн аргаар баяжуулж, 94.3 хувийн металл авалттайгаар төслийн нийт хугацаанд 54.74 кг шлихийн алт, химийн цэврээр 47.63 кг алт үйлдвэрлэнэ.

II.15. Ажиллах хүчний тооцоо

Ажилчдын орон тоог төслийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай техник технологи, төслийн хүчин чадал, тоног төхөөрөмжийн тоо нэг бүрийг харгалзан тооцоо. Төслийн хүчин чадлыг бүрэн ашиглахад хангалттай тооны ажилчдыг тусгаж өгсөн бөгөөд уурхайн ажлын горим 1 ээлжээр ээлжийн үргэлжлэх хугацаа 8 цаг, угаан баяжуулах хэсгийн ажлын горим 1 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 8 цаг байна.

Хүснэгт №7. Удирдлага зохион байгуулалт

Уулын хэсэг	Угаан баяжуулах хэсэг	Засвар механикийн хэсэг	Захиргаа, аж ахуй, үйлчилгээний хэсэг
Захирал, уурхайн дарга	Баяжуулагч	Механик-цахилгааны инженер	Нярав, нягтлан
ХАБЭА, БО-ны ажилтан	Усан механикч	Засварчин	Тогооч
Экскаваторын оператор			Жолооч
Утгуурт ачигчийн оператор			Үйлчлэгч, туслах
Автосамосвалын жолооч			
Бульдозерын оператор			

Хүснэгт №8. Төслийн нийт ажилчдын тоо

№	Хэсэг нэгж	1 дэх жил	2 дахь жил
1	Уулын хэсэг	13	13
2	Угаан баяжуулах хэсэг	6	6
3	Засвар механикийн хэсэг	4	4
4	Захиргаа, аж ахуй, үйлчилгээний хэсэг	7	7
5	Нийт	30	30

II.16. Барилга байгууламж

“Ноён тохой трейд” ХХК нь тусгай зөвшөөрлийн талбайд уурхайн захиргаа, засвар үйлчилгээний төв зэрэг барилга байгууламжуудыг байрлуулахаар тооцов.

Орд ашиглалтын хугацаа бага тул зөөж тээвэрлэхэд хялбар шийдлийг сонгосон болно. Дараах хүснэгтэд “Ноён тохой трейд” ХХК-ийн барилга байгууламжууд, бүтэц эдлэл, хэмжээг тусгалаа.

Хүснэгт №9. Барилга, байгууламжийн мэдээлэл

№	Барилгын нэр	Х.нэгж	Хэмжээ	Тайлбар
<i>Хотхон</i>				

1	Уурхайн удирдлагын байр	м ²	20	Зөөврийн сууц 1 ш
2	Ажилчдын сууц	м ²	28	40 тн контейнер-хаус 4 ш
3	Цайны газар	м ²	14	20 тн тохижуулсан контейнер 1 ш
4	Халуун ус болон угаалга	м ²	14	20 тн тохижуулсан контейнер 1 ш
Ил уурхай				
5	Засварын газар, сэлбэгийн агуулах	м ²	28	40 тн контейнер 1 ш
6	Засварын талбай	м ²	100	Шимт хөрсийг хуулж, талбайг тэгшилсэн байна
7	Түлшний ёмкост	тн	15	Шимт хөрсийг хуулж, талбайг тэгшилсэн байна

II.16.1. Уурхайн тосгон

Ажилчдын сууц: Уурхайн тосгон тусгай зөвшөөрлийн талбайд 14 м² талбай бүхий 4 ширхэг 20 тонны контейнерээс бүрдэнэ. Ажилчдын хотхоныг нийт 18 хүн, нөөц тооцсоноор 21 хүн зэрэг байрлах хүчин чадалтай, шаардлагатай тавилга, эд хогшлоор тоноглогдсон байна. Ажилчдын сууцыг 40 тонны контейнерийг засч тохижуулан хүн амьдрах тав тухыг бүрдүүлсэн байна. 1 контейнер-хауст 6 хүн амьдрахаар тооцлоо.

Хоолны газар: Цайны газар нь ажилчдын сууцны нэгэн адил 20 тонны контейнерыг засаж тохижуулан хүн тав тухтай хооллох орчныг бүрдүүлсэн байна. 1 контейнер-хауст 1 удаадаа 15-20 хүн зэрэг хооллох бөгөөд 1 хүнд дунджаар 2.4 м² талбай ноогдож байна.

II.16.2. Холбооны байгууламж

Уурхайн орчимд үүрэн телефоны G-Mobile, Mobicom, Unitel корпорацийн сүлжээ барьдаг. Уурхайн экскаватор, автосамосвал, бульдозер зэрэг үндсэн тоног төхөөрөмжийн операторууд, ээлжийн дарга нар богино долгионы радио холбоогоор хангагдана.

II.16.3. Түлшний агуулах

Түлшний агуулахаас тоног төхөөрөмжүүдийг түлшээр хангана. Түлшний агуулах нь 10 хоногийн нөөц буюу 15000 литр түлш хадгалах багтаамжтай байна. Эдгээр нь тусдаа шахуурга болон шүүлтүүртэй байна. Түлшийг шүүж цэвэрлэсний дараа тоног төхөөрөмжүүдийг түлшээр цэнэглэнэ. Мөн түлш ачих, буулгах хэсэгт гал унтраах, аянга зайлуулагч хэрэгслүүд байрлана. Түлш асгарч хөрсийг бохирдуулахаас сэргийлж автомашин цэнэглэх талбайг хатуу хучилттайгаар хийж өгнө.

II.16.4. Засвар механикийн барилга байгууламж

Уурхайн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг үйлдвэрийн талбайд байрлах засварын талбайд хийж гүйцэтгэнэ. Засварын талбайд дугуй засвар, гагнуур, компрессорын станц зэргийг эхний ээлжинд байгуулна.

II.16.5. Цахилгаан хангамж

Цахилгаан хангамжийн эх үүсвэр: Бор талын алтны шороон ордын уурхай нь Төмөр замын Багахангай-Баянгийн хоорондох 6 кВ хүчдэлийн агаарын шугамын №205 тулгуураас салбарлуулан, 6 кВ хүчдэлийн агаарын холболт авч, ТМ-100/6 кВа-ын хүчин чадалтай трансформатораас цахилгаан эрчим хүчээр хангаж байна.


II.16.6. Аянгаас хамгаалах байгууламж

Уурхайн шатах тослох материалын агуулах болон засварын талбайг аянгын хамгаалалтын төхөөрөмж, түүнийг ашиглах журмын дагуу шатах тослох материалын агуулах ба засварын талбай нь аянгын шууд цохилтоос хамгаалагдсан байна.

II.16.7. Зам харилцаа

“Ноён тохой трейд” ХХК-ийн “Бор тал” нэртэй газрын алтны шороон орд төслийн уурхайн лицензийн талбайд үүрэн холбооны бүх операторын сүлжээг ашиглах бүрэн боломжтой. Тус уурхай нь төв замаас 25 км орчим зайд байрлана

Засгийн газрын 2018 оны 379-р тогтоол “Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журам”-ын хүрээнд авто замын чиглэлийг тухайн бүс нутгийн газар зүйн онцлог, зэрлэг ан, амьтны тархац, нутагшилт, тэдгээрийн шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх байдал, аж ахуй нэгжээс уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх талаар гаргасан хүсэлт, урьд нь батлагдсан авто замын чиглэл, баригдсан авто болон бусад төрлийн замыг харгалзан тухайн авто замын нийт урт нь хамгийн бага байх зарчмыг баримтлан тогтооно.



Зураг №1. Төслөл хэрэгжих газрын гадаад зам тээврийн зураг

II.17.1. Усан хангамж, усны хэрэглээ

Төслийн талбай нь Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт харьяалагдана. Ил уурхай нь шүүрлийн усгүй болно.

“Бор тал” -ын алтны шороон ордын усны хэрэглээг уурхайд гаргасан 4ш гүний худгаас хангана. Худгийн нийт ундарга 9.1 л/с байна.

Гүний худгийн солбилцол нь 107⁰21"27.06, 47⁰30"54'09
107⁰19"15'07, 47⁰30"56'07

107°19'21"31.1, 47°30'56"07

107°21'27"30, 47°30'58"83 байна.

Уурхайн усны хэрэглээг БОНХАЖ-ын сайдын тушаалаар батлагдсан 2015.07.30-ны өдрийн А/301 тоот “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны нормоор тооцсон.

Хүснэгт №10. Төслийн нийт цэвэр усны хэрэглээ

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Нийт ашиглалтын жилд
1	Унд ахуй	м ³	450.7
2	Зам талбай	м ³	1,393.6
3	Технологи	м ³	203,340.0
4	Тэрбум мод	м ³	980.0
5	Нөхөн сэргээлтийн усалгаа	м ³	50,896.0
Нийт			257,060.3


Уурхайн хэрэгцээнд худгаас ашиглалтын хугацаанд нийт 257.0 мян.м³ ус хэрэглэхээр байна. Ордыг ашиглахад шаардлагатай усны ундрагын хэмжээ 8.3 л/с байна. Гүний худгийн ундарга 9.1 л/с бөгөөд уурхайн усны хэрэгцээг хангаж байна.

Төслийн хүрээнд MNS BS 8515:2019 стандартын дагуу хур борооны усыг хуримтлуулан зам усалгаа болон технологийн усанд ашиглахыг зөвлөмжилж байна. Энэхүү нь айл өрх, худалдаа үйлчилгээ, нийтийн үйлчилгээний газруудын угаалга, ариун цэврийн өрөө, зүлэг усалгаа зэрэг чанарын хувьд ундны бус зориулалтаар ахуйн хэрэглээнд ашиглах системд хамаарна. Харин хүнс, хоол бэлтгэх болон боловсруулах, хүнсний сав суулга угаах зэрэг ундны зориулалт, мөн хувийн ариун цэврийн хэрэглээний шаардлагад хамаарахгүй болно.

Тус стандартад борооны усыг гал түймэр унтраах, усалгааны зориулалтаар худалдан борлуулах тухай тусгайлсан зөвлөмж тусгаагүй боловч эдгээр хэрэглээг мөн үгүйсгээгүй болно. Энэ стандарт үерийн усны хяналтын систем сурилуулсан хувийн болон нийтийн хэрэглээний системд хамаарна. Борооны ус цуглуулах сав ашиглахад хамаарахгүй. Мөн уг стандартаар тусгай зориулалтын системийн бүрэлдэхүүн хэсгийн загварыг тогтоохгүй (заахгүй) бөгөөд шинээр баригдах болон өргөтгөх, шинэчлэн засварлах барилгад ашиглаж болно. Энэхүү стандарт саарал усыг дахин ашиглах системд MNS BS 8525-1:2015 хамаарахгүй болно.

Ус ашиглах төлбөр

“Ноён тохой трейд” ХХК нь “Бор тал”-ын алтны шороон ордод тухайн жилийн ус ашиглуулах дүгнэлтийг “Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаа”-тай байгуулах шаардлагатай.



Зураг №2. Төсөл хэрэгжих газрын худгийн байршлын зураг

Тухайн нутагт дэвсгэрт газар доорх усны түвшин жигд биш тул усны судалгаа гүйцэтгэж хамгийн боломжтой газарт худаг гаргуулсан. Энэ нь MV-007039 тоот тусгай зөвшөөрлийн талбайгаас гадна байрлах тул Сэргэлэн сумын тамгын газартай худаг байрлах газрын гэрээ байгуулж ажиллахыг зөвлөв.

Мөн багийн ИНХ-ын хүрээнд уурхайн үйл ажиллагаа бүрэн дууссаны дараа нөлөөллийн бүсэд байрлах тухайн нутгийн харьяат нэг айлд өөрийн эзэмшлийн 1 худгийг иж бүрдлээр нь хүлээлгэж өгнө.

II.18. Төслийн эдийн засаг

Хүснэгт №11 Эдийн засгийн үр ашгийн үндсэн тооцооны задаргаа

Үзүүлэлт	Х/нэгж	Үндэслэл	АХО	1 дэх жил	2 дахь жил	Нийт
Уулын цул	мян.м ³			123.67	247.34	371.01
Элс олборлолт	мян.м ³			64.64	104.81	169.45
Хөрс хуулалт	мян.м ³			59.03	142.53	201.56
Хөрс хуулалтын коэффициент	м ³ /м ³			0.91	1.36	1.19
Угаан баяжуулах элс (цулаар)	мян.м ³			64.64	104.81	169.45
Элсэн дэх алтны агуулга	мг/м ³			0.07	0.06	0.14
Элсэн дэх алт /шлихээр/	кг			4.84	6.63	11.46
Алт авалт	%			92.50	92.50	92.50
Алт гаргалт /шлихээр/	кг			4.47	6.13	10.60
Алт гаргалт /химийн цэврээр/	кг			3.94	5.40	9.33
Алтны үнэ	\$/унци	1,801.57				
Алтны үнэ (сүүлийн 6 сарын дундаж)	төг/гр	166,820.4				
Борлуулалтын орлого	сая.төг			649.89	890.91	1,540.79
Үйлдвэрлэл, үйл ажиллагааны зардал						
Уулын хэсгийн зардал	сая.төг			141.06	229.19	370.24
Баяжуулах хэсгийн зардал	сая.төг			190.17	297.11	487.28

Засвар механикийн хэсэг	сая.төг			31.03	46.17	77.19
Аж ахуй, үйлчилгээний хэсэг	сая.төг			49.93	72.02	121.95
Үндсэн хөрөнгийн элэгдэл	сая.төг			52.16	57.95	110.11
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	сая.төг	5.00%		32.49	44.55	77.04
Нөхөн сэргээлт, хаалтын зардал	сая.төг			38.06	88.82	126.88
Тусгай зөвшөөрлийн төлбөр	сая.төг			2.05	2.05	4.10
Газрын төлбөр	сая.төг			3.77	3.77	7.54
АТӨЯХАТ болон агаарын бохирдлын төлбөр	сая.төг			0.71	0.71	1.42
Орон нутгийг дэмжих сангийн зардал	сая.төг			15.0	15.0	30.00
Нийт зардал	сая.төг			556.42	857.32	1,413.74
<i>1 гр алтны бүрэн өөрийн өртөг</i>	<i>төг/гр</i>			<i>141,342</i>	<i>158,859</i>	<i>151,552</i>
Татварын өмнөх ашиг	сая.төг			93.46	33.59	127.05
ААНОАТ	сая.төг	10%; 25%		10.85	4.86	15.70
Цэвэр ашиг	сая.төг			82.62	28.73	111.34
ҮАМУ	сая.төг			134.77	86.68	221.45
Хөрөнгө оруулалт						
Барилга байгууламж	сая.төг		(160.00)			(160.00)
Машин тоног төхөөрөмж	сая.төг		(253.80)			(253.80)
Тавилга эд хогшил	сая.төг		(6.80)			(6.80)
Дэд бүтэц	сая.төг		(40.00)			(40.00)
Балансын үлдэх өртөг	сая.төг				344.70	344.70
Нийт хөрөнгө оруулалт	сая.төг		(460.60)	0.00	344.70	(115.90)
ХОДМУ	сая.төг		(460.60)	134.77	431.38	105.55
ХОДМУ (өссөн дүнгээр)	сая.төг		(460.60)	(325.83)	105.55	
Өнөөгийн цэвэр үнэ, цэнэ (NPV, @8%)	сая.төг	34.03				
Өгөөжийн дотоод норм, IRR жилд	%	22%				
Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа	жил	1.2				

Ш. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Ш.1. Байгаль орчны төлөв байдал

Газарзүйн нөхцөл: Төв аймгийн Сэргэлэн сум нь Монгол Улсын хөгжлийн бүсчлэлээр төвийн бүсэд багтаж физик газарзүйн бүсчлэлээр Хангай Хэнтийн уулархаг мужид хамаарна. Сэргэлэн сумын газар нутгийн хэмжээ 74000м² хавтгай дөрвөлжин талбайтай. Хэнтийн нурууны баруун урд шувтрагын нам өндөртэй бөмбөгөр оройтой уулсын дунд засаг захиргааны хувьд хойд талаараа Эрдэнэ сумтай зүүн урд талаараа Баян сумтай урд талаараа Баянцагаан сумтай баруун талаараа Алтанбулаг зэрэг сумтай хиллэн оршино.

Уур амьсгал: Агаарын температурын сарын дундаж нь 1 дүгээр сард -17.2⁰С, 7 дугаар сард 15.9⁰С хүрч байна.

Төв аймгийн агаарын харьцангуй чийгшил дунджаар 840 гПа байдаг. Агаарын чийгшил нь даралт, температураас хамаарч өөрчлөгдөх ба өвөл 845.5 гПа, зун 838.7-842.7 гПа байдаг байна. Төв аймаг орчимд салхины дундаж хурд 4.6-5 м/сек байдаг. Улирлын байдлаар авч үзвэл, салхины хурд хаврын улиралд 4.2-4.6 м/сек, өвлийн улиралд 3.7 м/сек, бусад улиралд 2.9-5 м/сек тус тус байдаг байна. Хур тунадасны олон жилийн дундаж хэмжээ 232.1 мм бөгөөд түүний 90% нь дулааны улиралд буюу 4-9 дүгээр сард ордог байна. Төслийн талбайд жилийн дундаж харьцангуй чийгшил 37-72% хүрч хамгийн хуурай 8-р сард 72% байна.

Усан хангамж: Төслийн талбай нь Хойд мөсөн далайн ай савын бөгөөд түр зуурын элбэг тэжээлтэй, Хэнтийн дэд мужийн Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт харьяалагдана.

Төслийн талбайд гадаргын ус байхгүй байна. Төслийн талбайд өөрийн эзэмшлийн 4 гүний худагтай бөгөөд нийт усны хэрэглээгээ хангаж ажиллана.

Хөрс, ургамал: Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт орших “Бор тал” нэртэй алтны шороон орд нь газрын гадаргын хувьд Орхон-Сэлэнгийн бэсрэг уулын мужийн Туулын дэд мужид харьяалагдана. Төсөл хэрэгжих талбай нь хөрс газарзүйн мужлалтаар хөрс био-уур амьсгалын холимог бүсчлэл бүхий Хангайн мужийн өндрийн бүсчлэлийн хэв шинж бүхий өмнөд Хэнтийн 52-р тойрогт багтана.

Тухайн бүс нутаг нь ургамал газарзүйн мужлалын хувьд Евроазийн тал хээрийн мужид хамаарна. Монгол орны хээрийн бүс нутгийг илтгэх Хялганат хээр тохиолдоно.

Амьтны аймаг: Төсөл хэрэгжиж буй нутаг нь газарзүйн мужлалаар Дундад Халхын тойрогт тал хээрийн бүсэд хамаарна. Тус уурхайд өмнө нь олборлолт явуулж байсан учраас амьтад үргэн дайжсан байна.

Тус суманд амьтны аймгаас нийтлэг буюу зөвхөн тал хээрийн нөхцөлд дасан зохицсон амьтад тохиолдоно. Үүнд: туулай хэлбэртнээс бор туулай, огодой, мэрэгчдээс үлийн цагаан оготоно, махан идэштнээс саарал чоно, хярс, үнэг, шувуудаас шоорон эвэрт болжмор, монгол болжмор, шилийн сар, хөхтөн амьтнаас цагаан зээр зэрэг амьтад элбэг таардаг. Энэхүү бүс нутагт тохиолдох 6 баг, 17 овог, 40 төрөлд хамаарах 54 зүйл хөхтөн амьтан байдаг.

Нийгэм, эдийн засаг: Засаг захиргааны төвүүд нь Улаанбаатар хоттой засмал болон шороон замаар холбогдсон. Утсан харилцаа сайн хөгжсөн. Өндөр хүчдэлийн шугам, төмөр замтай. Ордын орчим гадаргын ус байхгүй, хур тунадас ихтэй үед зарим хөндийд үерийн ус түрж урсаж байдаг. Нийгэм эдийн засгийн хувьд тус сум нийт 2067 хүн амтай, хүн амын нягтаршил 0.5, өрхийн тоо 815 байна.

IV. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

IV.1. Газрын гадаргад үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Уурхайд ачих, зөөж тээвэрлэх, боловсруулах тоног төхөөрөмж болон бусад машин механизмуудад урсгал засвар, техникийн үйлчилгээ хийх, төрөл бүрийн материал, сэлбэг хэрэгсэл, шингэн түлш, тос хүлээн авах, хадгалах, түгээх зориулалттайгаар засварын жижиг хэсэг ажиллана. Эдгээр үйл ажиллагааны явцад алтны шороон ордын газрын гадарга, хэвлий нь техникийн болон хүний хүчин зүйлийн нөлөөлөлд өртөхөөр байна,

IV.2. Агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

- Агаарын бохирдол /уурхайн малталт, овоолгууд, тээвэрлэлтийн зам болон хөрс хуулалт зэрэг технологи ажиллагаанаас тоос дэгдэнэ/,
- Тээврийн хэрэгслийн шаталтат хөдөлгүүрээс ялгарах утаа тортогоос үүсэх бохирдлын нөлөө,
- Түр суурьшлын бүсэд хог хаягдал, шатах тослох материалын үнэр хүрээлэн буй орчинд тархана,
- Үйлдвэрлэлийн дотоод тээврийн замын нөлөөгөөр хөрсний бүтэц алдагдсанаас нарийн ширхэгтэй тоос агаарт дэгдэж тэр хэмжээгээр орчны газрын хөрс, ургамлан нөмрөгийг доройтолд оруулах.

IV.3. Усан орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

- Төслөөс гадаргын усанд үзүүлэх нөлөөлөл байхгүй байна,
- Төслийн технологийн хэрэгцээнд хэрэглэх усыг газрын доорх усаас авч ашиглах учир гүний усны нөөцөд тодорхой хэмжээний хомсдол үүсэх,
- Төслийн үйл ажиллагаанаас ахуйн болон үйлдвэрийн хог хаягдал уурхайн орчинд тархаснаас хөрсийг бохирдуулснаас гүний усыг бохирдуулах,
- Тунаах нуурын далангийн суурийн бат бөх байдал, далан сэтэрч болзошгүй.

IV.4. Хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

- Хөрсний элэгдэл, эвдрэл, үржил шимийн доройтол эрчимжинэ,
- Уурхайн дотоод тээврээр хөрс, ургамал талхлагдана,
- Уурхайд олон салаа шороон зам үүссэнээс хөрсний элэгдэл эвдрэл үүсэх,
- Шатах тослох материалын ашиглалт, хадгалалтаас үүдэлтэй хөрсний бохирдол хязгаарлагдмал орчинд үүснэ,
- Түр суурьшлаас эх үүсвэртэй хог хаягдлаар хөрс бохирдох,
- Тунгаах нуурын шаланд тунасан лаг орчныг хөрсийг бохирдуулах.

IV.5. Ургамлан нөмрөг

- “Бор тал” -ын алтны шороон ордын үйл ажиллагаа явагдаад олон жил болж байгаа учир олон салаа зам гаргах, ус цуглуулах зорилгоор татсан шуудуу, газрын эвдрэлээс шалтгаалсан доройтол олборлох үйл ажиллагаа явагдсан хэсгээр байна. Цаашид ашиглалтын талбай нэмэгдэхийн хирээр ургамалд үзүүлэх сөрөг нөлөөний цар хүрээ тэлэх боловч нөлөөллийн эрчим өсөхгүй,
- Уулын ажлын үед тээвэрлэлт, түр зам ашиглалт, орчны газар ашиглалт, тоосжилтоос ургамлын ургах орчин доройтох.

IV.6. Амьтан

- Төслийн үйл ажиллагаа, машин техник, тоног төхөөрөмжийн дуу чимээ, хөдөлгөөнөөс амьтад дайжин амьдрах орчин өөрчлөгдөх,
- Уурхайн ухсан нүх суваг, шуудуу руу мал амьтан уурхайн талбай руу унаж, бэртэх аюултай.

IV.7. Нийгэм, эдийн засагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

- Төслийн нөлөөллийн бүсэд төвлөрсөн суурьшил байхгүй,
- Төслийн үйл ажиллагааны үед орон нутагт түр ажлын байр бий болно,
- Орон нутгаас нийлүүлэх боломжтой хүнсний хангамж, ахуйн хангамж, түлш шатахуун нийлүүлэлт зэрэг материаллаг эрэлт үүснэ,
- Улс орны төсөвт мөнгөн хуримтлал бий болгоно,
- Мөн үйл ажиллагааны явцад техникийн бүрэн бүтэн байдал алдагдах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаагүйгээс эсвэл гэнэтийн аюул осол гарснаас улбаалан ажилчдын эрүүл мэнд, амь нас эрсдэх зэрэг нийгэм эдийн засгийн олон сөрөг нөлөөлөл үүсэх магадлалтай.

V.5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Зорилго: "Ноён тохой трейд" ХХК -ийн “Бор тал” -ын алтны шороон ордын ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ буюу зайлшгүй хийж гүйцэтгэх ажлыг төлөвлөхөд байгаль орчны менежментийн төлөвлөгөө оршино.

“Бор тал” -ын алтны шороон ордын байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан бөгөөд БОМТ-нд багтах нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлууд хийгдэхгүй болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээх, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ний хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 14,360,000 төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах арга зүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт:

Энэхүү тайлангийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино. Үүнд:

- Агаарын чанар, хөрсөн бүрхэвч, гүний усанд төслийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг багасгах, бууруулах, арга хэмжээг тогтоох,
- Байгаль орчныг хамгаалахад хяналт тавих хугацаа, хариуцах эзэнг тогтоох,

- Шаардлагатай хөрөнгө зардлыг урьдчилсан байдлаар тооцож тодорхойлох зэрэг орно,
- БОМТ-ний дагуу үйл ажиллагаа явуулахад дагаж мөрдөх эрх зүйн баримт бичгүүдийг тодорхойлох,
- Мэргэжлийн байгаль орчны ажилтантай байх,
- БОМТ-ий тайлан болон БОМТ-ний хэрэгжилтийг цаг тухай бүрт холбогдох байгууллагуудад хүргүүлэх, тайлагнах, хүлээлгэн өгөх шаардлагатай.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар заасан. Хуулийн дээрх шаардлагын дагуу “Бор тал” -ын алтны шороон орд төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулав.

VI. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕМНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

VI.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт №12. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа, давтамж	Хариуцах эзэн	Зардал, 2023 он /төгрөг/	Гарах үр дүн	Баримтлах стандарт, аргачлал
Агаарын орчин						
1	Уурхайн дотоод тээвэрлэлтийн автозамуудад усалгаа хийх, ялангуяа хуурайшилттай хаврын улиралд тогтмол усалж байх, олон салаа зам гаргахгүй байх үүднээс замын тэмдэглэгээг хийх, үйл ажиллагаандаа мөрдөх	Төслийн үйл ажиллагааны явцад	"Ноён тохой трейд" ХХК	Дотоод төлөвлөлтөөр	Агаарын бохирдлоос сэргийлэх	-Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, - MNS 3384- 82, Агаар мандал. Сорьц авахад тавих үндсэн шаардлага, -MNS4585:2007, “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” -MNS5885:2008, “Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага” -MNS ISO4227:2002, “Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө”
2	Уурхайд агаарын шинжилгээг улиралд нэг удаа зайлшгүй мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж байх шаардлагатай;	Тогтмол	Байгаль орчны мэргэжилтэн	Дотоод төлөвлөлтөөр	Тоосжилтоос сэргийлэх	
3	Тээврийн хэрэгсэл хүнд даацын машины хурдыг тогтмолжуулах журам гаргаж мөрдүүлэх, машин техникийн үзлэг шалгалтыг төлөвлөгөөт хугацааны дагуу тогтмолжуулж, байгаль орчинд сөрөг нөлөөтэй, утаа, хорт хий ихээр ялгаруулах техникийн шаардлага хангахгүйг сүүлийн үеийн дэвшилтэт техник, технологээр шинэчилж, аюулгүй ажиллагааг хангах.	Жилд 1 удаа	Байгаль орчны мэргэжилтэн	300,000		
Хөрсөн бүрхэвч						
1	Олборлолт дууссаны дараа байгаль орчны унаган төрхийг хэвээр хадгалж үлдэхийн тулд нөхөн сэргээлтийн ажлыг чанартай гүйцэтгэж орон нутагт хүлээлгэн өгч байх	Тогтмол	Уурхайн удирдлага	Дотоод төлөвлөлтөөр	Хөрс элэгдэж эвдрэхээс сэргийлэх	- MNS 3298- 91, Шинжилгээнд сорьц авахад тавигдах ерөнхий шаардлагууд

2	Тээврийн хэрэгсэлийг маршрутын бус замаар явуулахгүй байх, хориглосон таних тэмдгүүдийг сайжруулах, нэмэгдүүлэх	2023 онд	"Ноён тохой трейд" ХХК	Осол эрсдэлийн төлөвлөгөөнд орсон.	Хөрс элэгдэл эвдрэлд орох, олон салаа зам үүсэхээс сэргийлэх.	- MNS 3310- 91, Хөрс. Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох - MNS 17.5.1.19-92, БОХ. Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийхэд тавигдах шаардлага, -MNS5850:2008, “Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” -MNS591:2008, “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” -MNS4919:2000, “Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага”
3	Өнгөн хөрсийг хуулан авах, уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө болон түүний явцад хуулан авсан өнгөн хөрсийг тусгайлан зассан овоолго байдлаар хадгалах.	Уурхайн олборлолт эхлэхээс өмнө	Уурхайн удирдлага	200,000	Нөхөн сэргээлтэнд ашиглах	
4	Шимт хөрсний овоолгыг салхинд хийсэх, усанд автах бохирдохоос хамгаалах урьдчилан сэргийлэх	Уурхай эхлэх үед	Уурхайн удирдлага	Дотоод төлөвлөлтөөр	ШТМ-с хөрс бохирдохоос сэргийлэх	
Усан орчин						
1	Унд ахуйн ус болон зам усалгааны усны дээж авч лабораториор шинжлүүлэх	Жилд 1 удаа	Байгаль орчны мэргэжилтэн	ОХШХ-нд зардал нь орсон.	Ундны усанд хяналт тавих	Усны тухай хууль, - MNS 3534-83, Усны шинжилгээнд зориулж сорьц авах -MNS6148:2010, “Усны чанар. Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” -MNS0900:2010, “ХБО. Эрүүл
2	Худгийг тоолууржуулах усны зарцуулалтыг тоолуурын заалтад үндэслэн хянаж байх, тооцоолсон усны хэрэглээг хэтрүүлэхгүй байх	-	"Ноён тохой трейд" ХХК	500,000	Гүний худаг	
3	ШТМ хөрсөнд асгарахаас сэргийлэх, асгарсан тохиолдолд тухай бүрт саармагжуулах арга хэмжээ авах	Уурхай эхлэх үед	Уурхайн удирдлага	Дотоод төлөвлөлтөөр	ШТМ-с хөрс бохирдохоос сэргийлэх	
Амьтан						
	Олборлолтын үйл ажиллагаа явуулсантай холбоотойгоор амьтны нөөц хомсдох,	Уурхайн талбайд	Уурхайн удирдлага	ОХШХ-нд зардал нь орсон	Уурхайн талбайд мал, амьтан унаж гэмтэхээс	-Амьтны тухай хууль /2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр/ -Ан агнуурын тухай

	-Ухсан нүх суваг, шуудуунд мал, амьтан унах, -Олборлолтын үед мэрэгч, мөлхөгчдийн амьдрах орчин алга болж, тэнд үүрлэх шавьжууд устгах.				сэргийлэх зорилгоор хашаа хамгаалалт хийх	/2000 оны 05 дугаар сарын 05-ны өдөр /
		Уурхайн ойр орчим	Уурхайн удирдлага	ОХШХ-нд зардал нь орсон	Хууль бус агнуур хийхгүй байхад анхаарч, хяналт тавих	
			Уурхайн удирдлага	ОХШХ-нд зардал нь орсон	Хаягдал усан сан руу шувуу унах, хаягдал усан сангаас ундаалхаас сэргийлж шувуу үргээгч байрлуулах	
Нийт дүн					1,000,000 төгрөг	

VI.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

“Бор тал”-ын алтны шороон ордод өмнөх жилүүдэд олборлолт явуулж байсан бөгөөд өмнөх олборлолт явуулсан жилүүдэд 31.81 га талбай эвдрэлд өртөнө. Ашиглалтын жилүүдэд дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийгээд ашиглалт дууссаны дараа 3 жилд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийхээр төлөвлөөд байна

VI.2.1. Тэрбум мод төслийн хүрээнд

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10-р сарын 04-ны өдрийн А/58 зарлигийн 2-т заасан тэрбум мод тарих төслийн хүрээнд 1000 ш модыг Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт тарина харин усалгааг Төв аймгийн Сэргэлэн сумын ЗДТГ хариуцахаар болсон.

Хүснэгт №13 Тэрбум мод төслийн хүрээнд

Тарих мод бутны төрөл зүйл	1 дэх жил
Хайлаас, Улиас, Хар мод, Бургас, Шар хуайс, Үхрийн нүд, Нохойн хошуу	1000 ш
Төсөвт өртөг	9,000.000

VI.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх газрыг Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас санал авсны үндсэн дээр эвдэрсэн газрыг техникийн нөхөн сэргээлт хийх ажлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэхээр санал, шийдвэрт хүрсэн.

Хүснэгт №14. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	1 дэх жилд	Нэгжийн өртөг, /мян.төг/	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт хууль бус гар аргаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон 6 га талбайд нөхөн сэргээлт хийх, ажлыг 2023-2024 оны хооронд хийж гүйцэтгэнэ	2 га	3,000.000	Монгол улсын хэмжээнд мөрдөгдөж буй хууль, журам, стандартын дагуу

V.4. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

Ашиглалтын талбайгаас 1 км зайтай нэг малчин өрхтэй. Уурхайн үйл ажиллагаа бүрэн дууссаны дараа нөлөөллийн бүсэд байрлах тухайн нутгийн харьяат нэг айлд өөрийн эзэмшлийн 1 худгийг иж бүрдлээр нь хүлээлгэж өгнө.

V.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн ашиглалтын талбай орчимд хийгдсэн судалгаагаар ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор бүртгэгдээгүй. “Ноён тохой трейд” биет болон биет бус соёлын өвийг хамгаалах ЮНЕСКО-ийн конвенцийг мөрдлөг болгон уурхай орчмын дурсгалт газрууд, өнгөрсөн үеийн хүн төрөлхтний түүхийн дурсгалууд, биет бус соёлын өв болох бүжиг, хөгжим, уламжлалт ахуй зэрэг соёлын олон янз байдлыг бий болгох гол хүчин зүйлсийг хадгалан үлдэх, хамгаалах чиглэлээр ажиллах ба энэ талаар авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж жил бүрийн БОМТ-д тусган хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэгтэй.

V.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

"Ноён тохой трейд" ХХК -ийн ажилтнууд ажлын хариуцлага алдах, ялангуяа үйл ажиллагааны явцад технологийн горим зөрчсөнөөс элдэв осол гарч, үйлдвэрлэлийн хэвийн ажиллагаа саатах, ажиллагсадын эрүүл мэнд хохирох, хөдөлмөрийн чадвараа алдах, тахир дутуу болох, хүний амь нас эрсдэх зэрэг осол аваар гарч болзошгүй тул аюулгүй ажиллагааг анхаарч ажиллах шаардлагатай.

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг /Ашиглалтын хугацаанд /	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	-Гэнэтийн осол аваар гарах, -Болзошгүй аюул, осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, -Галын гэнэтийн аюул үүсэх	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянаж ажиллах	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж	-	-	-	Тогтмол	-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, -MNS 5390:2004, “ХААЭА. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага”
2		Ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх	Уурхайн ажилчдад	1	-	-	Тогтмол	
3		Гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах	Уурхайн кемп орчимд	-	-	300,000	Уурхайн үйл ажиллагааны явцад	
4		Ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх	Уурхайн удирдлага	-	-	200,000	Тогтмол	
5		Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хэрэгсэлээр бүрэн хангах (өлмийний хамгаалалттай түрийтэй гутал, хамгаалалтын нүдний шил, дуулга, тоосны маск, ажлын бээлий гэх мэт)	Уурхайн ажилчид	-	-	ХАБЭА-н зардалд тусгагдсан	Жил бүр	
6		Уурхайн далан сэтэрч эргэлтийн ус алдагдаж орчныг бохирдуулах	Далан, хаягдлын санг үер усны үед хальж урсахаас урьдчилан сэргийлэх, байнга тогтворжуулж эвдрэл үүссэхээс урьдчилан сэргийлэх, хяналт мониторинг хийх	Уурхайн удирдлага	-	-	Дотоод төлөвлөлтөөр	
Нийт						500,000		

V.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Уурхайн үйл ажиллагаанаас бий болж буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах зарчмыг баримтлан ажиллах шаардлагатай. Эдгээрт:

Уурхайн хог хаягдлыг багасгах, хянах дотоод журам боловсруулж, хогийг ангилан ялгаж дахин ашиглах хог хаягдлын хувь хэмжээг нэмэгдүүлнэ.

Дахин ашиглагдах боломжтой хог хаягдлын ангилан ялгалтын хувь хэмжээг нэмэгдүүлж, уурхайн үйл ажиллагааны улмаас бий болсон дахин ашиглагдах хог хаягдлыг дахин боловсруулах зах зээлд нийлүүлэх үйл ажиллагааг бий болгоно.

Хүснэгт №16. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэг-жүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хог хаягдлаас орчны бохирдол үүсэх	Хог тээвэрлэх компанитай байгуулсан гэрээний дагуу хогийг цаг хугацаанд нь тээвэрлүүлж байх	Хөрс, агаар, газрын доорх ус	-	360,000	-	360,000	Жил бүр	Хог хаягдлын тухай хууль
Нийт зардал					360,000				

V.8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

"Ноён тохой трейд" ХХК -ийн Байгаль орчны мэргэжилтэн нь байгаль орчны асуудлыг хариуцан ажиллаж, БОХТ, БОХШХ-ийг хэрэгжүүлж, хэрэгжилтийн үр дүн, тайланг компаний удирдлага, байгаль орчныг хариуцсан бүх шатны төр, захиргааны байгууллагын өмнө хариуцан ажиллах үүрэг хүлээнэ.

Хүснэгт №3. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа, давтамж	Хэрэгжүүлэгч	Зардал, 2023 он /төгрөг /
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх	Тогтмол	Компаний удирдлага	Дотоод төлөвлөлтөөр
2	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлыг жил бүрийн тайланг БОАЖЯ болон Сэргэлэн сумын ЗДТГ-т хүргэн өгч байх	11 сард	"Ноён тохой трейд" ХХК	Дотоод төлөвлөлтөөр
3	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хэрэгслээр бүрэн хангаж ажиллуулах	Төслийн үйл ажиллагааны явцад	Компаний удирдлага	Үйл ажиллагааны зардалд орсон
4	Ажилчдыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулах	Жилд 1 удаа	Компаний удирдлага	Дотоод төлөвлөлтөөр
5	Гал унтраах хэрэгслээр уурхайг бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар арга хэмжээ зохион байгуулах	Жил бүр	"Ноён тохой трейд" ХХК	Осол эрсдэлийн төлөвлөгөөнд орсон.
6	Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	Төслийн хугацаанд	"Ноён тохой трейд" ХХК	Тохиролцох

V.9. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө

"Ноён тохой трейд" ХХК нь жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага, нутгийн иргэдэд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөг дараах хүснэгтэд үзүүлэв.

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөгүй үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны мэргэжилтэн нь төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна.

Хүснэгт №18. Олон нийтэд тайлагнах, танилцуулах төлөвлөгөө

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд		Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Зохион байгуулах газар
Төв аймаг	Орон нутгийн байгаль орчны газар	Хуралд танилцуулах	БОМТ-ийн 2023 оны хэрэгжилтийн тайлан	11-р сарын 01-ний өдрийн дотор	Уурхайд
	БОАЖЯ-ны ХБОБНУГ	Уулзалт			БОАЖЯ-ны ХБОБНУГ-т
Төрийн захиргааны төв байгууллага	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны засаг дарга	Тайлан, төлөвлөгөөг тайлан хэлбэрээр болон Файл хэлбэрээр	2023 оны БОМТ	12-р сарын 01-ний өдрийн дотор	Засаг даргын тамгын газарт

V. 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

“Бор тал” нэртэй алтны шороон ордыг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тухай бүрт илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдалд тодорхой орон зайд, тодорхой хугацааны дотор, тодорхой давтамжтайгаар ажиглалт, хэмжилт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөр гэнэ.

2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт байгаль орчны төлөв байдлын өөрчлөлт, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ үр дүнтэй байгаа эсэх, сөрөг нөлөөллийн эрчим, цар хэмжээ нь зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг тогтоох ажиглалт, хэмжилт, дээжлэлт хийх байршил, давтамж, хариуцах этгээд, шинжилгээний арга, шаардагдах зардлыг тооцож тусгана.

“Ноён тохой трейд” ХХК нь үйл ажиллагааныхаа явцад байгаль орчинд учруулж буй нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтийг хянаж, байгаль орчныг хамгаалах ажлын үр дүнд тулгуурлан цаашид авах арга хэмжээг нарийвчлан төлөвлөх зорилгоор орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай.

№	Хяналт шинжилгээ явуулах үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хяналтын хугацаа, давтамж	Зардал, 2023 он /төгрөг/	Баримтлах стандарт, аргачлал
Агаарын орчин					
1	Агаарын тоосны (TSP, PM ₁₀ , PM _{2.5}) шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх				-MNS 4585-2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, -MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, -MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга
2	Агаарын бохирдлын (NO ₂ , SO ₂ , CO, Тоос) шинжилгээ хийлгэж байх	Уурхай орчим, кемп орчмоос	Олборлолтын талбайд 1 цэгт жилд 2 удаа /хавар, зун/	250,000	-MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, -MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, -MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогворжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга
Усан орчин					
1	Усны хяналт шинжилгээ: Усны чанар: рН, ууссан нийт давс (жингийн аргаар), нийт хатуулаг (CaCO ₃), Ca, Mg, Na, K, SO ₄ , NO ₂ , NO ₃ , NH ₄ , As, Cd, Cu, Hg, Pb, Zn, Cr, Fe, Ni, үнэр, өнгө, нүүрс устөрөгчид (нефть бүтээгдэхүүний бохирдол)	Унд ахуйн усыг хангаж буй гүний уснаас, тунаах нуураас.	Жилд 2 удаа	100,000	-MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж -MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага -MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл Усны түвшин (газрын гадаргаас ахуйн шаардлага, түүнд тавих хяналт

Хөрсөн бүрхэвч					
1	Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент (NO ₃ , P ₂ O ₅ , K ₂ O), хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд, кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайр	Төслийн талбайд 2 цэг сонгох. /уурхайн шимт хөрсний овоолго, ахуйн бохир усны хаягдал орчимд/	Жилд 2 удаа	150,000	- MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, - MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох арга - MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага - MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. - MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга
Нийт дүн				500,000 төгрөг	

V.11. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ЗАРЦУУЛАХ НИЙТ ЗАРДАЛ

“Ноён тохой трейд” ХХК-ийн 2023 оны БОМТ-г БОНХЯ-ны Сайдын 2014 оны 1 сарын 06-ны өдрийн “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа. 2023 онд БОМТ-нд нийт **14,3** сая төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

Хүснэгт №20. 2023 оны БОМТ-ний нийт зардал

№	Арга хэмжээ	Зардал, 2023 он /төгрөг/
1	Байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	1,000,000
2	Биологийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	-
3	Тэрбум мод төслийн хүрээнд	9,000,000
4	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	3,000,000
5	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	360,000
8	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	500,000
10	Олон нийтэд тайлагнах төлөвлөгөө	-
11	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	500,000
Нийт дүн		14,360,000

VIII. ДҮГНЭЛТ

“Ноён тохой трейд” ХХК-ний Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших “Бор тал”-ын алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланг хийж гүйцэтгэлээ.

2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээнүүдийг тухай бүрт хэрэгжүүлж тухайн онд хийсэн ажлаа холбогдох газруудаар хянуулж батлуулах шаардлагатай байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 2023 онд нийт 14,4 сая.төг зарцуулахаар төлөвлөлөө.

“Ноён тохой трейд” ХХК нь байгалийн унаган төрхийг хамгаалахын тулд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж зэргийг мөрдлөг болгон ажиллах хэрэгтэй.

Мөн олборлолтонд өртсөн талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг зохих дүрэм, журмын дагуу чанартай гүйцэтгэх шаардлагатай байна.

Энэхүү тайлангийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний ажлуудыг холбогдох стандарт, арга аргачлалын дагуу тогтоосон хугацаанд чанд сахин биелүүлж байх хэрэгтэй.

Уурхайн үйл ажиллагааны үед хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг сайтар чанд сахих, аюулын үед хэрэгжүүлэх дотоод төлөвлөгөөтэй ажиллах шаардлагатай.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ, НОМ ЗОХИОЛ

1. Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он
2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2012 он
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачилсан заавар УБ 2010.
4. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын стандартуудын эмхтгэл УБ 2010.
5. Журам шинэчлэн батлах тухай Байгаль орчин аялал жуулчлалын Сайдын А-36 тоот тушаал, 2011 оны 2 дугаар сарын 16, 1-р хавсралт
6. “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” БОАЖСайдын А/618 тоот тушаал, 2019 он.
7. Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших “Бор тал” -ын алтны шороон ордыг
8. ил аргаар ашиглах төслийн БОННУ-ий нэмэлт тодотголын тайлан
9. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, аудитын журам, аргачлал /гарын авлага/
УБ 2014 он
10. Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны
өдрийн А-618 дугаар тушаалын хавсралт, “Байгаль орчны менежментийн
төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах” журам.
11. www.mne.mn